

МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 24 өдөр

№ 1/36

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Компанийн дүрмийн 10.6.12, Хөдөлмөрийн дотоод журмын 2.2, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн “Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгох, ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг нийт ажилчдад мөрдүүлж ажиллахыг Байгаль орчин, хөдөлмөр хамгааллын хэлтэс /Ч.Сүхбаатар/-т даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны газар (О.Энхбаяр)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.АЛТАНЦЭЦЭГ



“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”
ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 05
сарын 17-ны эдрийн 36 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХУВЦАС, НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ ОЛГОХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго, хамрах хүрээ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (цаашид “компани” гэх)-ийн нийт ажилтнуудын зун, өвлийн ажлын хувцас болон нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгох, ашиглах, бүртгэх, хянах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслүүдийн стандартуудыг удирдлага болгосон бөгөөд компанийн нийт ажилтнууд дагаж мөрдөнө.

Хоёр. Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл

- 2.1. Ажлын хувцасны өнгө, загвар, иж бүрдлийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн хурлаар хэлэлцэж Гүйцэтгэх захирал батална.
- 2.2. Ажлын хувцас нь батлагдсан өнгө, загвар, иж бүрдэл бүхий стандартын шаардлага хангасан байхаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.2.1. Ажлын хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочирол, шархлаа үүсгэхгүй, ширүүн хурц ирмэггүй байна.
 - 2.2.2. Ажлын хувцас нь биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц байна.
 - 2.2.3. Ажлын хувцас нь зэрэглэл сайтай, бөх бат хийгдсэн, хөнгөн, чанартай, эдийн засгийн хувьд үр ашигтай байна.
- 2.3. Ажлын хувцасны иж бүрдэл нь дараах хэсгээс бүрдэнэ.
 - 2.3.1. Өвлийн ажлын хувцас - хүрэм, өмд
 - 2.3.2. Зуны ажлын хувцас - Хүрэм, өмд, зуны нимгэн цамц, зузаан флийс цамц, хамгаалалтын гутал
- 2.4. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн иж бүрдэл нь дараах хэсгээс бүрдэнэ.
 - 2.4.1. Гар хамгаалах хэрэгсэл
 - 2.4.2. Толгой хамгаалах хэрэгсэл
 - 2.4.3. Нүд хамгаалах хэрэгсэл
 - 2.4.4. Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл
 - 2.4.5. Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл
 - 2.4.6. Өндрийн бүс
 - 2.4.7. Гэрэл ойлгогч хантааз
- 2.5. Хөдөлмөр хамгааллын хувцасны ерөнхий шаардлага:
 - 2.5.1. Өвлийн хүрэм, өмд - MNS ISO 13688 : 2000

- 2.5.2. Зуны цамц, өмд - MNS ISO 13688 : 2000
- 2.5.3. Зузаан цамц - MNS ISO 13688 : 2000
- 2.5.4. Гар хамгаалах хэрэгсэл - MNS 5622 : 2006
- 2.5.5. Хамгаалалтын гутал - MNS 5623 : 2006, ISO 20345 : 2011
- 2.5.6. Толгой хамгаалах хэрэгсэл - MNS 5621 : 2006
- 2.5.7. Нүд хамгаалах хэрэгсэл - MNS 5389 : 2004, EN 166 : 2002
- 2.5.8. Өндрийн бүс - EN 361 : 2002
- 2.5.9. Гэрэл ойлгогч хантааз - MNS 6231 : 2011

Гурав. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах
хэрэгслийг олгох, эдэлгээний хугацаа

- 3.1. Компанийн инженер, техникийн ажилтнуудыг ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр иж бүрэн хангана.
- 3.2. Туршилтын хугацаагаар ажиллаж байгаа ажилтанд ажлын хувцас олгохгүй бөгөөд хамгаалалтын гутал болон нэг бүрийн хамгаалах хэрэгслийг тур хугацаанд олгоно.
- 3.3. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг санхүү хариуцсан нэгж зохих журмын дагуу бүртгэл хөтөлж олгоно.
- 3.4. Ажилтан ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн ашиглалтын хугацаа дуусах, цэвэрлэх боломжгүй болох, аюулгүйн шаардлага хангахгүй болох зэрэг шалтгааны улмаас солих шаардлага гарсан бол шууд удирдлагадаа хүсэлт гаргах ба компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан нэгж, санхүү хариуцсан нэгж хэлэлцэж дахин олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.5. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажлын нөхцөл, эдэлгээний хугацаагаар тооцон олгоно.
- 3.6. Хөдөлмөр хамгааллын хувцасны угаалга, цэвэрлэгээг ажилтан өөрөө хариуцна.
- 3.7. Ашиглах боломжгүй болсон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг акт үйлдэн устгана.
- 3.8. Ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тохиолдолд ажилласан хугацаагаар хувцасны элэгдэл, хороодлыг тооцож санхүү хариуцсан нэгжтэй тооцоо хийнэ.
- 3.9. Үйлдвэрийн талбай болон барилгын талбайн ажилтай танилцах зочдыг толгой хамгаалах хэрэгсэл, гэрэл ойлгогчтой хантааз зэргээр түр хангана.
- 3.10. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг дараах хугацаагаар олгоно.

Үүнд:

- 3.10.1. Инженер, техникийн ажилтнуудад зун болон өвлийн хувцас, хамгаалалтын гутлыг 24 сард нэг удаа, бусад ажилтнуудад зуны хувцсыг 36 сард нэг удаа олгоно.
- 3.10.2. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажлын талбайд ажиллах бүрт түр олгоно.

Дөрөв. Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг ашиглах

- 4.1. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тухайн ажилтан хариуцах үүрэгтэй.
- 4.2. Ажилтан ажлын талбайд ажил гүйцэтгэхдээ ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.
- 4.3. Ээлжийн амралт, ажлын бус цагаар ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.
- 4.4. Эвдрэл, гэмтэлтэй хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг хатуу хориглоно.
- 4.5. Ажлын хувцасны өнгө, загварыг өөрчлөхийг хориглоно.
- 4.6. Ажлын хувцсыг өмсөж хэрэглэхдээ биедээ тохируулан цэвэр үзэмжтэй, зөрчилгүй, ариг гамтай эдлэж хэрэглэх үүрэгтэй.

Тав. Хяналт, хариуцлага

- 5.1. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн зүй ёсны хэрэглээ, бүрэн бүтэн байдалд компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан нэгж хяналт тавих, мөрдүүлж ажиллах, зөрчлийг илрүүлж мэдэгдэх үүрэгтэй.
- 5.2. Журам зөрчсөн ажилтанд компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/01 тушаалаар баталсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам”-ын 13.1 дэх заалтын дагуу эрх бүхий ажилтан сахилгын шийтгэл ногдуулна.
- 5.3. Энэхүү журмыг зөрчсөн ажилтны санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг гэмтээх, ашиглах боломжгүй болгох, алга болгосон тохиолдолд учирсан хохирлыг ажилтан өөрөө барагдуулна.

--- оОо ---



“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”
ТӨХХК-ийн Хөдөлмөр хамгааллын хувцас,
хэрэгслийг олгох ашиглах журам”ын хавсралт

НЭГ БУРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ САНАМЖ

Нэг. Нүд хамгаалах хэрэгсэл

- 1.1. Ажилтан барилгын талбайд аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын нүдний шилийг заавал зүүх ёстой.
- 1.2. Хамгаалалтын нүдний шил нь ямарваа нэг биет нүүр рүү үсрэх, хайлсан металл, химийн шингэн бодис, хүчил, идэмхийн шингэн, химийн хий болон уур, мөн гэрлийн туяанаас хамгаалдаг.
- 1.3. Ажилтан шаардлагатай тохиолдолд нүүрэндээ гэмтэл авахаас урьдчилан сэргийлж нэмэлт хамгаалалт бүхий чанарын шаардлага хангасан нүүрний хаалт зүүх шаадлагатай.
- 1.4. Байгалийн гамшигт үзэгдэл, салхи, шуурга, хурц нартай үед нүдний шил зүүж ажиллахыг зөвлөдөг.
- 1.5. Барилгын ажил явагдаж буй талбай болон үйлдвэрийн хэсэгт контакт линз зүүх тохиромжгүй.

Хоёр. Хөл хамгаалах хэрэгсэл

- 2.1. Барилгын ажил явагдаж буй талбай болон үйлдвэрийн хэсэгт хөл хамгаалах зориулалтын ажлын гутлыг өмсөх ёстой бөгөөд гутлыг сайтар үдсэн байх шаардлагатай.
- 2.2. Ажилчид халтирах, хурц зүйлд хатгуулах аюулаас сэргийлж хамгаалалтын гутлын ул элэгдсэн эсэхийг тогтмол шалгаж байх үүрэгтэй.
- 2.3. Хамгаалалтын гутал нь аливаа унах, эргэх биет, ул тавхай хатгах, цахилгааны аюул, хайлсан металл, халуун гадаргуу, хальтиргаатай гадаргуу зэргээс шалтгаалах хөл гэмтэх эрсдэлээс хамгаалах зорилготой.

Гурав. Гар хамгаалах хэрэгсэл

- 3.1. Ажилтан гар гэмтэх магадлалтай ажил хийж гүйцэтгэхдээ тухайн ажилд тохирсон гарын хамгаалалт бүхий бээлийг заавал өмсөнө.
- 3.2. Хамгаалалтын бээлий нь зүсэгдэх, шалбарах, түлэгдэх, цочрох, химийн бодист өртөх зэрэг эрсдлүүдээс хамгаалах зорилготой хэрэглэгдэнэ.
- 3.3. Хамгаалалтын бээлийг гагнуур хийх, халуун нөхцөл, тастагч ажиллуулж байгаа үед заавал өмсөх ёстой.
- 3.4. Химийн бодис бүхий материал, цахилгааны шугам, техниктэй харьцах үед зориулалтын резинэн тусгаарлагчтай бээлий өмсөнө.

Дөрөв. Амьсгал хамгаалах хэрэгсэл

- 4.1. Үйлдвэрийн талбайд шаардлагатай үед тоос, галын аюул, утаа, угаар, болон агаарын найрлага дахь хортой бодисоос хамгаалах зорилгоор нэг удаагийн амны хаалт, хошуувчтай амьсгалын баг, агаарын нөөцлүүртэй амьсгалах

- хэрэгсэл, амьсгалын аппарат зэрэг амьсгал хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.
- 4.2. Агаарт тархсан тоосонцор, утаяа тортог, хорт утаяа, хий, уур манан бүхий орчинд ажиллагсад тухайн нөхцөлд тохирсон зориулалтын амьсгал хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.
 - 4.3. Ажилтан нь өөрийн хэрэглэж буй амьсгал хамгаалах хэрэгслийн найдвартай ажиллагаа, цэвэр тоосгүй байдлыг тогтмол хангаж байх шаардлагатай.

Тав. Өндрийн бүс

- 5.1. Өндрийн бүсийг хашлага, хаалт болон бариул байхгүй нөхцөлд өндөрт болон хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн дээр ажиллах үед хэрэглэнэ.
- 5.2. Ажилчид өндрийн бүсийг хэрэглэхийн өмнө өөрийн биеэр хамгаалалтын хэрэгсэлд ямарваа нэгэн эвдрэл гэмтэл байгаа эсэхийг сайтар шалгах үүрэгтэй.
- 5.3. Эвдрэл гэмтэлтэй, шаардлага хангахгүй өндрийн бүс хэрэглэхийг хатуу хориглоно.
- 5.4. Өндрийн бүсийг хэрэглээгүй үед зориулалтын газар зөв хурааж хадгална.

Зургаа. Толгой хамгаалах хэрэгсэл

- 6.1. Толгой хамгаалах хэрэгсэл нь дээрээс аливаа гадны биет унахад толгойг хамгаалах зориулалттай.
- 6.2. Толгой хамгаалах хэрэгслийг ашиглахаас өмнө түүний бүрэн бүтэн байдлыг үргэлж шалгана.
- 6.3. Толгой хамгаалах хэрэгслийн өмсөх бүслэвчийг өөрийн толгойны хэмжээнд тохируулан өмсөж, тохируулагч цагиргаар хэмжээг тохируулж хөдөлгөөнгүй суулгаж өмссөний дараа ажлаа эхэлнэ.

--- oOo ---